


БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Я.АМАРЖАРГАЛ



НИЙЛҮҮЛЭГЧ

ЛАЙФТРОНИК ХХК
ГҮЙЦЭТГӨХ ЗАХИРАЛ

Д.БАТДАВАА



ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,
АРИУТГАЛЫН БОДИС, ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 22

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас Лайфtronик ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь оношлуур худалдан авах гэрээг (цаашид "бараа" гэх) 161,519,600₮ (нэг зуун жаран нэгэн сая таван зуун арван есөн мянга зургаан зуун) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Д/Д	Барааны нэр, төрөл	Багц	Үйлдвэр, Улс	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	Полимеразан гинжин урвалын мастер мiks цомог ("AgPath-ID One-Step RT-PCR)	Багц 35	АНУ, Thermofish er	1хайрцаг 1*1000 ширхэг	5	10,120,000₮	50,600,000₮
2	Полимеразан гинжин урвалын малти мастер мiks цомог NxTAG Respiratory	Багц 36	Герман, Mikrogen, Франц, Biomerieux	1*50/*12 /1*30/*2	7	9,900,000₮	69,300,000₮

	Pathogens Panel Targets						
3	Сорьц тээврлэх тэжээлт орчин M-5. Хамар залгиурын арчдасын сорьц авах цомгийн хамт	Багц 41	Итали, Copan	1*50	100	330,000₮	33,000,000₮
4	Фильтртэй ариун пипеткийн хошуу Brand Pipette tips, 2-20µl, 732728	Багц 42	Герман, Brand	0,5-10 мкл (Brand Pipette tips)	6	495,000₮	2,970,000₮
5	Фильтртэй ариун пипеткийн хошуу Brand Pipette tips, 2-20µl, 732728	Багц 43	Герман, Brand	2-2,0 мкл (Brand Pipette tips)	6	470,800₮	2,824,800₮
6	Фильтртэй ариун пипеткийн хошуу Brand Pipette tips, 50-1000µl, 732734	Багц 44	Герман, Brand	50-100,0 мкл (Brand Pipette tips)	6	470,800₮	2,824,800₮

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **161,519,600₮** (нэг зуун жаран нэгэн сая таван зуун арван есөн мянга зургаан зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
2. Нийлүүлэгч нь **Багц-35**-ийн **50,600,000₮**(тавин сая зургаан зуун мянга) төгрөг, **Багц-36**-ийн **69,300,000₮**(Жаран есөн сая гурван зуун мянга) төгрөг, **Багц-41** – ийн **33,000,000₮** (гучин гурван сая) төгрөг, **Багц-42** -ийн **2,970,000₮**(хоёр сая есөн зуун далан мянга) төгрөг, **Багц-43** -ийн **2,824,800₮** (хоёр сая найман зуун хорин дөрвөн мянга найман зуу) төгрөг , **Багц-44** -ийн **2,824,800₮** (хоёр сая найман зуун хорин дөрвөн мянга найман зуу) төгрөгийн барааг **2020** оны **02** дугаар сарын **13**-ны өдрөөс **2020** оны **03** дугаар сарын **05**-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 Тендер ба үнийн хуваарь;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 Санхүүжилтийн хуваарь.

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтгүй.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Урьдчилгаа /төгрөг/ 50%	Үлдэгдэл Гүйцэтгэл /төгрөг/
1	Полимеразан гинжин урвалын мастер микс цомог ("AgPath-ID One-Step RT- PCR")	Багц 35	25,300,000₮	25,300,000₮
2	Полимеразан гинжин урвалын малти мастер микс цомог NxTAG Respiratory Pathogen Panel Targets	Багц 36	34,650,000₮	34,650,000₮
3	Сорьц тээвэрлэх тэжээлт орчин M-5, Хамар залгиурын арчдасын сорьц авах цомгийн хамт	Багц 41	16,500,000₮	16,500,000₮
4	Фильтртэй ариун пипеткийн хошуу Brand Pipette tips,2-20μl, 732728	Багц 42	1,485,000₮	1,485,000₮
5	Фильтртэй ариун пипеткийн хошуу Brand Pipette tips,2-20μl, 732728	Багц 43	1,421,400₮	1,421,400₮
6	Фильтртэй ариун пипеткийн хошуу Brand Pipette tips,50-1000μl, 732734	Багц 44	1,421,400₮	1,421,400₮
	Нийт дүн			161,519,600₮

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) "Гэрээ" гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) "Гэрээний үнэ" гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.

- (в) "Хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) "Хүчинтэй болох хугацаа" Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) "Ашиглагч" Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) "ГЕН" Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) "Бараа" Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм, эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) "Захиалагч" гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) "Бүртгэлийн гэрчилгээ" хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) "ГТН" Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) "Үйлчилгээ" гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) "Байршил" ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) "Нийлүүлэгч" ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

2. Үйлчлэх хүрээ	2.1 Энэ өрөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.
3. Барааны гарал үүслийн улс	3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно
	3.2 Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
4. Стандарт	4.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь Техникийн тодорхойлолтод заагдсан стандартад нийцсэн байна. Тусгайлсан стандарт заагдаагүй тохиолдолд тухайн барааны гарал үүслийн улсын холбогдох стандартад нийцсэн байна. Энэ стандарт нь холбогдох байгууллагын хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбар байна.

- 5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах**
- 5.1 Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 5.2 Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 5.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 5.3 ГЕН-ийн 5.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
- 5.4 Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
- 6. Бүртгэлийн гэрчилгээ**
- 6.1 Гэрээгээр нийлүүлэгдэх эм нь Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн байна.
- 6.2 Эмэнд бүртгэлийн гэрчилгээ аваагүй бол Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн мэдэгдэлийг эрх бүхий этгээдээс авснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 7. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 7.1 Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 8. Гүйцэтгэлийн баталгаа**
- 8.1 Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 8.2 Нийлүүлэгч гэрээний ажлаа дуусгаж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 20.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
- 8.3 Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар захиалагч хүлээн зөвшөөрөх дараах төрлийн баталгаа байна. Үүнд:

- (а) Тендерийн баримт бичгийн Бүлэг VII-д заасан маягтаар гаргасан банкны баталгаа, эсхүл
- (б) Засгийн газрын бонд эсхүл
- (в) Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаас
- 8.4 Нийлүүлэгч гэрээний ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 9. Шалгалт болон туршилт**
- 9.1 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй.
- Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 10. Баглаа боодол**
- 10.1 Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон гэрэл, чийг зэргийг хангалттай тээвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих буулгах хангалттай төхөөрөмж байхгүй зэргийг харгалзсан байна.
- 10.2 Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, түүний дотор гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
- 11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 11.1 Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 11.2 Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж

- гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
12. Даатгал 12.1 Үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг гэрээний тусгай нөхцөлд заасан хэлбэрээр даатгуулна.
13. Дагалдах үйлчилгээ 13.1 Нийлүүлэгч ГТН-д заасан дагалдах үйлчилгээг гүйцэтгэнэ.
13.2 Хэрэв гэрээний үнэд тусгагдаагүй бол дагалдах үйлчилгээний зардлыг талууд харилцан тохиролцож нийлүүлэгчид төлнө. Энэ зардал нь захиалагчийн бусад гүйцэтгэгчид төлсөн ижил төстэй үйлчилгээний зардлаас хэтрэхгүй байна.
14. Чанарын баталгаа, 14.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ үйлдвэрлэгдсэн, өмнө ашиглагдаагүй бөгөөд үйлдвэрлэсэн болон хүчинтэй байх хугацааг хангасан байна. ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, үйлчилгээ нь нийлүүлэгдэх үед 2 жилээс дээш хадгалалтын хугацаатай барааны (5/6) нь өнгөрөөгүй, 2 ба түүнээс доош хадгалалтын хугацаатай барааны хувьд (3/4) нь өнгөрөөгүй болохыг нийлүүлэгч баталгаажуулна.
- Мөн гэмтэл согоггүй бөгөөд гэрээний нөхцөлүүд болон техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагаас чанарын шаардлага хангаагүй үндэслэлээр хэрэглээнээс хасагдаагүй, орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.
- 14.2 Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр нийлүүлэгдсэнээс хойш 3 сарын дотор мэдэгдэнэ. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой барааг үнэ төлбөргүй солино.
15. Төлбөр 15.1 Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд дурьдана.
- 15.2 Нийлүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай бараа нийлүүлэлтийн гүйцэтгэлийг захиалагчид хүргүүлнэ. Уг гүйцэтгэлд нийлүүлсэн бараа үйлчилгээний нэхэмжлэх, ГЕН-ийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагатай баримт бичгийг хавсаргана.
- 15.3 Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 15.4 Гэрээний дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

- 16. Үнэ**
- 16.1 Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. Гэрээний тусгай нөхцөлийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 17 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 17. Захиалгыг өөрчлөх**
- 17.1 Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг өөрчлөх эрхтэй:
- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
 - (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр
 - (в) барааг хүргэх газар
 - (г) нийлүүлэгчийн гүйцэтгэх үйлчилгээ
- 17.2 Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид өөрчлөлт гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаа болон үнэд үзүүлэх нелөөг (хэрэв нелөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг өөрчилнэ. Өөрчлөлттэй холбоотой аливаа гомдол, саналыг захиалгыг өөрчлөх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид гаргана.
- 18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 18.1 ГЕН-ийн 17-т зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- 19. Гэрээний үүргийг шилжүүлэх**
- 19.1 Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 20. Гүйцэтгэлийн хугацаа сунгах**
- 20.1 Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрднө.
- 20.2 Гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгч бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлэхэд урьдчилан тооцоогүй нөхцөлийн улмаас хугацаа алдах байдал үүссэн бол захиалагчид шалтгаан, үргэлжлэх хугацааг бичгээр шуурхай мэдэгдэнэ. Мэдэгдлийг авсан даруй захиалагч байдлыг үнэлж гүйцэтгэгчийн ажлын хуваарийг сунгах шийдвэрийг алданги оногдуулах эсхүл оногдуулахгүй нөхцөлтэйгээр гаргаж гэрээнд өөрчлөлт оруулна.

- 20.3 ГЕН-ийн 23-т өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгчийн нийлүүлэлттэй холбоотой үүргийн биелэлтийг хангуулах үүднээс ГЕН-ийн 21-д заасны дагуу алданги оногдуулна. ГЕН-ийн 20.2-т гүйцэтгэлийн хугацааг алданги оногдуулахгүйгээр сунгахаар тохирсон бол энэ заалт хамаarahгүй.
21. Алданги оногдуулах
- 21.1 ГЕН-ийн 23 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч гэрээг ГЕН-ийн 22 дугаар зүйлийн дагуу цуцлах асуудлыг хөндөж болно.
22. Үүргээ биелүүлээгүй гээс гэрээг цуцлах
- 22.1 Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад эрх, үйл ажиллагаагаа үл хөндөн нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй:
- (а) Нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл 20 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
- (б) Бараа нь гэрээнд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй; эсхүл
- (в) ГТН-д заасан хугацаанд тухайн барааны бүртгэлийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг ирүүлээгүй бол.
- (г) Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авилгал, залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
- (д) Нийлүүлэгч гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
- 22.2 ГЕН-ийн 22.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал	23.1 ГЕН-ийн 20, 21 ба 22-т заасныг үл харгалзан, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас хугацаа алдсан эсхүл гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх боломжгүй болсон гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаа, алданги, эсхүл үүргээ биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдах хариуцлагыг хүлээхгүй.		
23.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.			
24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах	24.1 Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрх, үйл ажиллагааг хөндөхгүй.		
25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах	25.1 Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсныг болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.	25.2 Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ:	(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
26. Маргааныг шийдвэрлэх	26.1 Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцэл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.		

- 26.2 Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
27. Гэрээнд зүйлзах хэл
27.1 Гэрээ нь ГТН-д заасан хэл дэр бичигдэнэ. ГЕН-ийн 28-д өөрөөр заагаагүй бол энэ хэл дээр бичигдсэн гэрээний хувилбарыг гэрээг тайлбарлахад мөрдөнө. Гэрээний дагуу талуудын харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.
28. Гэрээнд мөрдех хууль
28.1 ГТН-д заагаагүй бол Гэрээ нь Монгол улсын хуулийг мөрдөнө.
29. Мэдэгдэл
29.1 Талууд гэрээтэй холбогдсон мэдэгдлийг бичгээр болон факсаар ГТН-д заагдсан хаягаар хүргүүлнэ.
29.2 Мэдэгдэлийг түүний хүргэгдсэн өдөр эсхүл түүнд заасан хүчинтэй хугацааны аль сүүлчийн өдрөөс хүчинтэй гэж үзнэ.
30. Татвар болон хураамж
30.1 Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас нийлүүлэх бараанд Монгол улсын гадна оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
30.2 Дотоодоос нийлүүлэх бараанд захиалагчид нийлүүлэгдэх хүртлэх хугацаанд түүнд оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)

ГЕН 1.1 (и)	Захиалагч нь Эрүүл мэндийн яам
ГЕН 1.1 (о)	Нийлүүлэгч нэр: ЛАЙФТРОНИК ХХК
ГЕН 1.1 (н)	Байршил: Дандарбаатарын гудамж 32, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар 13321, Монгол Улс
ГЕН 1.1 (е)	Ашиглагч байгууллага: ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг тусгай мэргэжлийн төв, бусад байгууллага

2. Тайлчлэх хүрээ (ГЕН-ийн Зүйл 2)

ГЕН 2	ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

3. Барааны гарал үүслийн улс (ГЕН-ийн Зүйл 3)

ГЕН 3	ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

4. Стандарт (ГЕН-ийн Зүйл 4)

ГЕН 4	Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан стандарт болон бусад шаардлагууд
-------	---

5. Гэрээний баримт бичгийг хэрэглэх (ГЕН-ийн Зүйл 5)

ГЕН 5	ГЕН-ийн 5-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

6. Барааны бүртгэлийн гэрчилгээ (ГЕН-ийн Зүйл 6)

ГЕН 6.1	Монгол улсад бүртгэгдсэнийг нотлох холбогдох бүртгэлийн болон бусад гэрчилгээ
---------	---

7. Оюуны өмчийн эрх (ГЕН-ийн Зүйл 7)

ГЕН 7	ГЕН-ийн 7-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

8. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)

ГЕН 8.1	Гэрээний үнийн дунгийн 5% -аар гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
ГЕН 8.4	Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

9. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)

ГЕН 9.1	ХӨСҮТ-ийн холбогдох мэргэжилтнүүд шалгаж, туршина.
---------	--

10. Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)

ГЕН 10.2	Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан стандарт болон бусад шаардлагууд
----------	---

11. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт

ГЕН 11.1	(CIP нөхцөл)
----------	--------------

Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд:

Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсан даруй энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, ачсан боомт, боомтоос гарах огноо, тээврийн хэрэгслийн нэр, буулгах боомт зэргийг дурдана.

Нийлүүлэгч дараах баримт бичгийг² захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ: Барааг онгоцоор тээвэрлэх тохиолдолд нислэгээс дор хаяж 48 цагийн өмнө тээврийн хэрэгслийн нэр, нислэгийн дугаар, бараа ирэх хугацаа, тээврийн баримтын дугаар зэргийг захиалагчид мэдэгдэнэ.

Захиалагч мэдэгдлээ факсаар ирүүлж дараах баримт бичгийг захиалагчид, хуулбарыг даатгалын компанийд баталгаат шуудангаар хүргүүлнэ. Үүнд:

- a. нийлүүлэгчийн нэхэмжлэхийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувь. Үүнд захиалагчийн нэр, хаяг [гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих]; гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг зааж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан байна;
- b. Захиалагч [гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих] болон гэрээнд заасан бусад мэдэгдэх байгууллагыг дурдаж, Техникийн шаардлагын хуваарыт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хэлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувийг болон бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн 2 ширхэг хуулбар хувийн хамт; эсхүл Техникийн шаардлагын хуваарыт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэгслийн “Тээврийн хэлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий 3 хувь баримт
- c. Барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт;
- d. Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар;
- e. Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг хуулбар хувь
- f. Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн Шалгалтын гэрчилгээний үндсэн хувь;
- g. Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг
- h. “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцснийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар

Монгол улсын дотроос нийлүүлэх барааны хувьд:

Гүйцэтгэгч бараа хүрэлцэн ирэхэд эсхүл ирэхээс өмнө захиалагчид бичгээр мэдэгдэж дор жагсаасан баримт бичгийг захиалагчид өгсөн байна. Үүнд:

1. Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан нийлүүлэгчийн нэхэмжлэхийн хувь; 2 ширхэг үндсэн, 2 ширхэг хуулбар хувь
2. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарыт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын

² Инкотермсүн аль нөхцөлийг ашиглахаас төдэн бусад зохих баримт бичгийн нэрийг жагсаана.

эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн бараа хүргэсэн баримт, 2 хувь

3. Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар
4. Барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт;
5. Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг үндсэн хувь
6. Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн шалгалтын гэрчилгээний хуулбар хувь;
7. Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг
8. "ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем"-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар

Санамж: Нийлүүлэгчийн ирүүлсэн баримт бичиг нь гэрээний шаардлагад нийцэхгүй бол төлбөрийг ГТН-ийн 9 (ГЕН 9)-ийн дагуу хийх шалгалт туршилтын дүнг үндэслэн төлнэ.

12. Даатгал (ГЕН-ийн Зүйл 12)

ГЕН 12.1	Гэрээ нь СИР үнэд үндэслэсэн тохиолдолд даатгал нь "агуулахаас агуулахад" дайн болон ажил хаялтыг оруулсан "бүх эрсдэл" нөхцөлтэй, СИР үнийн 110 %-ийн дунтэй байна.
-------------	--

13. Дагалдах үйлчилгээ (ГЕН-ийн Зүйл 13)

ГЕН 13.1	(a) Нийлүүлэгч барааг Монгол Улсад хэрэглэхэд шаардагдах бүх тусгай зөвшөөрөлийг авсан байна. Үүнд гарах зардлыг гэрээний үнэд багтсан гэж үзнэ. (b) Нийлүүлэгч техникийн тодорхойлолтод заасан дагалдах үйлчилгээг гүйцэтгэнэ.
-------------	--

14. Чанарын баталгаа (ГЕН-ийн Зүйл 14)

ГЕН 14.1	Захиалагчийн техникийн шаардлагын дагуу барааг нийлүүлэх, хэрэв шаардлагад нийцэхгүй бараа нийлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна. Захиалагч нь хагарч гэмтсэн шаардлагад нийцэхгүй барааг буцааж, шаардлага хангасан бараагаар солиулна.
-------------	--

ГЕН 14.2	Гэмтэлтэй барааг солих хугацаа: 3 хоног
----------	---

15. Төлбөр (ГЕН-ийн Зүйл 15)

ГЕН 15.1 & 15.4	Гэрээний дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийг төгрөгөөр хийнэ. Шинэ коронавирусийн халдвартын эрсдлийн үнэлгээгээр Монгол улс ӨНДӨР эрсдэлтэй гэж үнэлэгдсэн тул эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлтийг яаралтай зохион байгуулах зорилгоор гэрээний дагуу гүйцэтгэгчид хийх төлбөрийг дараах нөхцөлөөр хийнэ. 1.Урьдчилгаа төлбөр: Гэрээний үнийн дүнгийн 50 хүртэлх хувиар урьдчилгаа төлбөр олгож болно. Урьдчилгаа төлбөрийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 5 хоногийн дотор нийлүүлэгчийн гаргаж ирүүлэх нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна)
-----------------	--

2. Барааг хүлээн авахад төлөх: Нийлүүлсэн барааны гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл төлбөрийг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон ХӨСҮТ-д барааг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.

16. Үнэ (ГЕН-ийн Зүйл 16)

ГЕН 16.1 Гэрээний хэрэгжилтийн явцад үнэ тогтмол байна.

17. Захиалгыг өөрчлөх (ГЕН-ийн Зүйл 17)

ГЕН 17 Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний үнийн дүнгийн 25% хүртэл хэмжээгээр эм, эмнэлгийн хэрэгсэл, оношуур, ариутгалын бодисыг эсхүл хорогдуулж болно. Нэмэлт нийлүүлэлтээр авахдаа гэрээ байгуулсан нэр төрлийн нэгж үнийг баримтлана.

18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах (ГЕН-ийн Зүйл 18)

ГЕН 18 ГЕН-ийн 18-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

19. Гэрээний үүргийг шилжүүлэх (ГЕН-ийн Зүйл 19)

ГЕН 19 ГЕН-ийн 19-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

20. Хугацаа сунгах (ГЕН-ийн Зүйл 20)

ГЕН 20 ГЕН-ийн 20-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

21. Алданги оногдуулах (ГЕН-ийн Зүйл 21)

ГЕН 21.1 Хугацаа хэтэрсэн тохиолдолд долоо хоногт гэрээний үнийн 0.5 хувиар алданги тооцно.

22. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 22)

ГЕН 22 ГЕН-ийн 22-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал (ГЕН-ийн Зүйл 23)

ГЕН 23 ГЕН-ийн 23-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 24)

ГЕН 24 ГЕН-ийн 24-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)

ГЕН 25 ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй

26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)

ГЕН 26 ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй

27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)

ГЕН 27.1 Монгол хэл

28. Гэрээнд мөрдөх хууль (ГЕН-ийн Зүйл 28)

ГЕН 28.1 Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө

29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)

ГЕН 29.1 Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2

30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)

ГЕН 30 Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн

хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
.....
..... Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
.....
..... Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
.....
..... Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
.....
..... Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан
Бодогч
.....
..... Х.Ариунтуяа

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн
Мэргэжилтэн
.....
..... Д.Мөнхцэцэг

14210 Улаанбаатар хот Сүхбаатар
дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын
VIII байр

Утас:263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Лайфtronик ХХК-ийн
Борлуулалтын менежер
.....
..... Л.Гэрэлмаа

Хаяг: Дандарбаатарын гудамж 32
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар
Утас: 7575-4422, 99032240

Регистрийн дугаар:5803454
Банк: Худалдаа хөгжлийн банк
Дансны дугаар: 404215228

ТОЛБОРИЙН ХҮССЭЛТ № 1

2020 оны 3 сарын 4 өдөр

Байгууллагын нэр:	Эрүүл монголын наадам	Дансчын дугаар
Регистрацийн дугаар:	9087443	100900020414
Хүчиний аватчийн нэр:	Лайфтроник ХХК	Дансчын дугаар
Регистрацийн дугаар:	5803454	404215228
Хүчиний аватчийн банк:	Худалдаа хөгжлийн банк	80,759,800.00
Мөнгөн дүүрүүсээр:	Нийин сая одоонон зуун тасгин өсөн авсан иштэлан зүйн тогтолцоого мөнгө	Антидил
Гүйлгүүний утга:	70202 - Сайнхүү, тохир, эдийн засгийн нийтийн уйлчилгаа	
Шинэ корпоративийн хувьбаарлын үеэд ёМ-н туслах ж гүйцэтгэх шийдвэр 3/1 тоот 50%	81101 - Засгийн тээврийн поши хөрөнгө 210901 - Бараа үйчинийн бусал зардал	80,759,800.00
Хяналтын хуудас № 1		
Үндсэлэх баримт бичийн нэр:	Он, сар, өдөр, дугаар	Төрийн санжийн тэмдийн тээвэр
1. Ажил, үйчинийгүйчээж, бүтээгдэхүүн худалдан авалттай холбоогсон гүйцэтгэгий байгуулсан гүрүү	2020.02.22	У
2. Нэмэгжих	2020.03.03	У

Төрийн санжийн тэмдийн тээвэр
20 онд сарын өдөр
тэмдэг, гарын УСЭГ
Тамга Дарга: / Я.Амаржаргал /
Нийтлан бологч: / М.Амжилт / • Х.Аршуунтуяа /